



НЭР БҮХИЙ 44 АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ КОМПАНИУДАД

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-17-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2016.06.30 № 9/2242

танай _____-ны № _____-т

Мэдээлэл ирүүлэх тухай

Танай байгууллагыг Хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн.

Хорооноос тус журмын хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа хийгдэж байгаа тул журмыг хангаж байгаа талаарх дараах нотлох баримтыг 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг мэдэгдэж байна. Үүнд:

1. Аудитын тухай хуулийн 19.4-д зааснаар “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх эрхтэй аудитын хуулийн этгээд нь дөрвөөс доошгүй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байна” гэж зохицуулагдсан тул орон тооны 4 аудиторуудын аудитын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
2. Хороо болон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
3. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
4. Мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;
5. Аудиторууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн тодорхойлолт.

Тогтоосон хугацаанд нотлох баримтыг бүрэн ирүүлээгүй тохиолдолд тус журмын 4.4.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон гэж үзэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.6-д “Хороо нь үнэт цаасны зах зээлд аудитын, хөрөнгийн үнэлгээний болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу танай байгууллагыг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах болохыг мэдэгдэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНЦАЦРАЛ



000258